



141

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

Г “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”
ажиллах журам батлах тухай

“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 17.1 заалтыг үндэслэн эмнэлэгт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, “Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх” стратегийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эмнэлэгт “Эмийн эмчилгээг зохицуулах хороо” ажиллах журмыг нэгдүгээр, эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх болон антибиотик эмийн хэрэглээний мэдээ, антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн, тайлангийн маягтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. “Эмийн эмчилгээг зохицуулах хороо”-г шинэчлэн зохион байгуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж ажиллахыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, амаржих газар, клиникийн болон ор бүхий хувийн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Эмийн эмчилгээг тасралтгүй, жигд, оновчтой төлөвлөж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай эмийн сонголт, хангамжийг сайжруулах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг, сувилал, хувийн эмнэлгийн дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Я.Буянжаргал/ - д даалгасугай.
5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2005 оны 71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Н.УДВАЛ

082166

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 10 дугаар сарын 17-ны
өдрийн 336 дүгээр тушаалын
1 дүгээр хавсралт

ЭМИЙН ЭМЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эмнэлэгт эмийн эмчилгээг зохицуулах хороо (цаашид "хороо" гэх)-ны ажиллах бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагаа эрх, үүргийг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хорооны зорилго нь эмнэлэгт "Төрөөс эмийн талаар баримтлах бодлого", "Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх" стратегийн хэрэгжилтийг зохицуулж, эмчилгээний өндөр идэвхтэй, чанарын баталгаатай эмийн сонголт, түгээлт, хадгалалт, хэрэглээ, хүртээмжид хяналт тавих, эмийн эмчилгээг тасралтгүй, жигд, оновчтой, үр ашигтай болгох, нянгийн дасал, мэдрэг чанарын зүй тогтлыг тандах, судлах, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчид эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

1.3. Хороо нь "Эмийн талаар төрөөс баримтлах бодлого", "Эрүүл мэндийн тухай" хууль, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичиг, бусад хууль тогтоомж, стандартыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллана.

1.4. Хороог төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, клиникийн болон оп бүхий хувийн эмнэлэгт зохион байгуулна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1. Эмнэлгийн хүчин чадал, хүний нөөцийн хангамжаас хамааран хорооны бүрэлдэхүүн нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв (оп бүхий) нь эмчилгээ эрхэлсэн дарга, клиникийн эм судлаач, эм зүйн албаны эм зүйчид, чанарын менежер, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, халдварт судлаач эмч, сувилахуйн арга зүйч, санхүүгийн асуудал хариуцсан ажилтан зэрэг (9 - оос доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.1.2. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар нь эмчилгээ эрхэлсэн дарга, клиникийн эм судлаач, эм зүйн албаны эм зүйчид, чанарын менежер, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, сувилахуйн арга зүйч, санхүүгийн асуудал хариуцсан ажилтан зэрэг (7 - оос доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.1.3. Клиникийн болон оп бүхий хувийн эмнэлэг нь эмчилгээ эрхэлсэн дарга, эм судлаач, эм зүйч, чанарын менежер, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, сувилахуйн арга зүйч зэрэг (5 - оос доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.3. Хороог эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тэргүүлэх бөгөөд нарийн бичгийн даргаар эмнэлгийн клиникийн эм судлаач эсвэл эм зүйн албаны эрхлэгч байна.

2.4. Хорооны дарга “Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх” стратегийг хэрэгжүүлэх, эмнэлэгт антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийн зохистой хэрэглээтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах 3 - аас доошгүй хүнийг хорооны гишүүдээс сонгон, хариуцуулна.

2.5. Хороо нь эмнэлгийн даргаар батлуулсан ажлын нарийвчилсан төсөв, төлөвлөгөөтэй ажиллана.

2.6. Хорооны үйл ажиллагаанд шаардлагдах зардлыг эмнэлгийн байгууллага жил бүр төсөвтөө тусган, санхүүжүүлнэ.

Гурав. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны эрх, үүрэг

3.1. Хороо нь дараах эрх эдэлнэ.

3.1.1. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний удирдамж, эмчилгээний стандарт боловсруулахад санал өгөх;

3.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ эм, Монгол улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм хэрэглэх, эмчилгээнд хэрэглэж байсан эмийг ижил үйлчилгээтэй эмээр солих, зарим эмийн хэрэглээнд нас болон тунгийн хязгаарлалт хийх, гаж нөлөө ихтэй нь тогтоогдсон болон эмчилгээний үр дүнгүй эмийг эмчилгээнээс хасах зэргээр Хүний эмийн зөвлөлд асуудал дэвшүүлэх;

3.1.3. Тендерийн материал боловсруулах, бэлтгэх болон тендерийн үнэлгээний хороонд гишүүнээр оролцох;

3.1.4. Тендерээр худалдан авч байгаа эмийн сонголт, чанар, зарцуулалт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг үнэлэх;

3.1.5. Эмийн эмчилгээний тасалдлыг хянах, эмчийн заалтаар хэвтэн эмчлүүлэх үед үйлчлүүлэгчээр авчуруулж эмчилгээнд хэрэглэсэн эмийг эргүүлэн төлөх асуудлыг эмнэлгийн удирдлагад дэвшүүлэх;

3.1.5. Нянгийн дасал, мэдрэг чанарын зүй тогтлыг судлан тандахад эмч, мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.6. Нян эмэнд тэсвэржих үзэгдлээс сэргийлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварт тархалтыг зогсох, эрсдлийг бууруулах, анхаарал татаж буй нянгийн эмнэлзүйн сорилт бүхий хяналтыг сайжруулах талаар салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан мэдээлэл солилцох;

3.1.7. Эмнэлэгт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;

3.1.8. Эмийн чанар, хангамж, хэрэглээтэй холбогдсон аливаа зөрчлийг арилгуулахаар эмнэлгийн удирдлага, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, зөвлөмж дүгнэлт гаргах, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.1.19. Хорооны ажлыг гүйцэтгэхэд эмнэлгийн эмч, мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.10. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар улс, орон нутаг, байгууллагын түвшний хурал, зөвлөгөөн, ярилцлага, сургалтанд оролцох, зохион байгуулах;

3.2. Хороо нь дараах үүрэг хүлээнэ.

3.2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийг зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад, антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийг

зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон мэдрэг чанарыг тодорхойлсон дунд үндэслэн сонгох;

3.2.2. Эмийн эмчилгээний үр дүнг тооцон эмийн хэрэглээг үнэлэх, эмчилгээний болон эдийн засгийн үр ашиггүй эмийн хэрэглээг бууруулах, эмийн үнэ, эмийн эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хяналт, судалгаа хийх, үр дүнг тайлагнах;

3.2.3. Эмийн гаж нөлөөг бүртгэн, мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох журмын дагуу гаж нөлөөний мэдээллийг хэлэлцэн, үнэлж Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст хүргүүлэх;

3.2.4. Гаж нөлөө үүсгэх эрсдэл өндөртэй, эмчилгээний индекс багатай эмийн жагсаалтыг эмнэлгийн тусlamж, үйлчилгээний онцлогтоо тохируулан гаргаж, жагсаалтад орсон эмийн гаж нөлөө илэрсэн үед авч хэрэгжүүлэх стандарт үйл ажиллагааны заавар боловсруулан баталж, мөрдүүлэх;

3.2.5. Эмийн хэрэглээтэй холбоотой тохиолдолж болзошгүй эрсдэл, эмчилгээний алдаа дутагдлаас сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

3.2.6. "Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх" стратегид заасан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх;

3.2.7. Тасгуудад хэрэглэж буй антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийн хэрэглээг үнэлэх, нянгийн дасал, мэдрэг чанарын зүй тогтлыг судлан тандах, үр дүнг эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд тайлагнах;

3.2.8. Эмнэлгийн тусlamж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх аргачлал, гарын авлага, удирдамж боловсруулахад оролцох;

3.2.9. Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах, хяналт тавьж ажиллах;

3.2.10. Эмнэлгийн эмч, мэргэжилтэнг улсын бүртгэлд бүртгэгдсэн шинэ эмийн мэдээллээр хангах, эмийн эмчилгээг оновчтой, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй төлөвлөх чадварыг бий болгох ажлыг зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах;

3.2.11. Антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийн зохистой хэрэглээний талаарх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлага, хандлагыг системтэй дээшлүүлэх, антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийг өвчтөнд бичих үндэслэл, жор бичилтийг сайжруулах сургалтыг зохион байгуулах;

3.2.12. Эмнэлэгт хэвтэн эмчилүүлж буй болон амбулаториор үйлчлүүлэгчдэд эмийг ялангуяа антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийг эмчийн зааврын дагуу зөв зохистой хэрэглэх хэрэглээний талаарх мэдээлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

Дөрөв. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан мэдээг ирүүлэх

4.1.1. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, клиникийн эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан эмийн хэрэглээний мэдээг маягт 1, антибиотик эмийн хэрэглээний талаарх мэдээг маягт 2, эмнэлгийн хэмжээнд хийсэн антибиотик мэдрэг чанарын үзүүлэлтийн дүнг маягт 3, хорооны ажлын тайланг маягт 4-ийн дагуу дагуу бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст дараа оны 1 сарын 10-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

4.2.2. Ор бүхий хувийн эмнэлгүүдийн эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан эмийн хэрэглээний мэдээг маягт 1, антибиотик эмийн хэрэглээний талаарх мэдээг маягт 2, эмнэлгийн хэмжээнд хийсэн антибиотик мэдрэг чанарын үзүүлэлтийн дүнг маягт 3, хорооны ажлын тайланг маягт 4-ийн дагуу дагуу бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан Эрүүл мэндийн газартаа дараа оны 1 сарын 05-ны дотор бичгээр болон холбогдох эмийн мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

4.2.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар ~~эмийн~~ эмчилгээг зохицуулах хорооны нэгтгэсэн дүнг, тайлангийн хамт Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэст дараа оны 1 сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

Тав. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах

5.1. Эмнэлгийн эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагаах үнэлэх, зохицуулах ажлыг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд хариуцан ажиллана.

5.1.1. Хорооны үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн дүгнэх;

5.1.2. Тайлан, мэдээтэй холбоотой шаардлагатай зөвлөмжийг эмнэлэг бүрт эргэн мэдээлэх;

5.1.3. Тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан маягт 1, 2, 3 - ын дагуу ирүүлсэн статистик мэдээг нэгтгэн, жил бүрийн "Эрүүл мэндийн үзүүлэлт" номонд мэдээлэх;

5.1.4. Хорооноос ирүүлсэн гаж нөлөөний мэдээллийг Хүний эмийн зөвлөлийн Эм судлалын салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, зохицуулалтын арга хэмжээг авах;

5.1.5. Эмнэлгүүдийн эмийн эмчилгээг зохицуулах хороотой хамтран хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах.

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 10 дүгээр сарын 17-ны
өдрийн 336 дүгээр тушаалын
2 дугаар хавсралт

Эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээ

Эмнэлгийн нэр он

Маягт 1

| Тасгийн нэр | | | |
|--|--|--|--|
| Нийт хэвтэн эмчлүүлсэн өвчтөний тоо | | | |
| Эмчилгээнд хэрэглэсэн эмийн нийт тоо | | | |
| Нийт хэрэглэсэн эмэнд эзлэх антибиотик эмийн тоо | | | |
| Нийт хэрэглэсэн эмэнд эзлэх тарилгын эмийн тоо | | | |
| Нийт хэрэглэсэн эмэнд зайлшгүй щаардлагатай эмийн эзлэх хувь | | | |
| Нийт хэрэглэсэн эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо | | | |
| Эмчилгээ, оношилгооны удирдамжийн дагуу эмчилгээнд хийгдсэн эмийн эзлэх хувь | | | |
| Тухайн тасагт хэвтэн эмчлүүлсэн өвчтөний дундаж ор хоног (эмчлүүлсэн хугацаа) | | | |
| Нэг өвчтөнд хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн эмийн дундаж тоо | | | |
| Нэг өвчтөнд хэвтэн эмчлүүлэх хугацаанд хэрэглэсэн эмийн дундаж үнэ | | | |
| Хэвтэн эмчлүүлэх хугацаанд өвчтөнөөр авчуулж эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн эмийн тоо | | | |
| Өвчтөнөөр авчуулж эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн эмийн нийт үнэ | | | |

Эмийн хэрэглээний тооцоо гаргасан:

Нарийн мэргэшил _____

Албан тушаал _____

Эмнэлгийн антибиотик эмийн хэрэглээний талаарх мэдээ



Эмнэлгийн нэр он

Маягт 2

| | | | |
|--|--|--|--|
| Тасгийн нэр | | | |
| Нийт хэвтэн эмчлүүлсэн өвчтөний тоо | | | |
| Антибиотик эмийн эмчилгээ хийсэн өвчтөний тоо | | | |
| Антибиотик мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ хийсэн өвчтөний тоо | | | |
| Эмчилгээнд хэрэглэсэн нийт антибиотик эмийн тоо | | | |
| Нийт хэрэглэсэн антибиотик эмэнд эзлэх тарилгын эмийн тоо | | | |
| Нийт хэрэглэсэн антибиотик эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо | | | |
| Нийт хэрэглэсэн антибиотик эмнээс зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь | | | |
| Нэг өвчтөнд хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн антибиотик эмийн дундаж тоо | | | |
| Нэг өвчтөнд хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн антибиотик эмийн дундаж үнэ | | | |
| Нийт хэрэглэсэн антибиотик эмэнд бүлгүүдийн эзлэх хувь | | | |
| Пенициллиний бүлэг | | | |
| Макролидын бүлэг | | | |
| Цефалоспорины бүлэг | | | |
| Тетрациклиний бүлэг | | | |
| Аминогликозидууд | | | |
| Карбапенемүүд | | | |
| Липопептидүүд | | | |
| Оксазолидон | | | |
| Бусад | | | |

Антибиотик эмийн хэрэглээний тооцоо гаргасан:

Мэргэшил _____

Албан тушаал _____

Эмнэлгийн антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн

Эмнэлгийн нэр он

Маягт 3

| Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон хүний тоо | Мэдрэг /%/ | Мэдрэг бус /%/ |
|--|------------|----------------|
| Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн | | |
| Пенициллиний бүлэг | | |
| Макролидын бүлэг | | |
| Цефалоспорины бүлэг | | |
| Тетрациклиний бүлэг | | |
| Аминогликозидууд | | |
| Карбапенемүүд | | |
| Липопептидүүд | | |
| Оксазолидон | | |
| Бусад | | |

Мэдээ гаргасан:

Мэргэшил _____

Албан тушаал _____

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан

Эмнэлгийн нэр

..... он

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны удирдлага, зохион байгуулалтын талаарх товч танилцуултыг бичих.

Маягт 4

| № | Үйл ажиллагааны чиглэл | Хийсэн ажил | Хүрсэн үр дүн | Цаашид асуудал, санал | Анхаарах дэвшүүлэх |
|----|--|-------------|---------------|-----------------------------|-----------------------|
| 1. | Эмийн хангамж, хүртээмж | | | | |
| 2. | Эмийн чанар, аюулгүй байдал | | | | |
| 3. | Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагаа | | | | |
| 4. | Антибиотик болон нянгийн эсрэг үйлдэлтэй эмийн хэрэглээ, хяналт | | | | |
| 5. | Эмийн жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангамж | | | | |
| 6. | Эмийн эмчилгээний үр дүн, эмийн хэрэглээ, эмийн эмчилгээний чанар, ертөг зардлын талаар хийсэн үнэлгээ, судалгаа /Хийсэн үнэлгээ, судалгааны дүнг хавсаргана./ | | | | |
| 7. | Эмийн зохистой хэрэглээний мэдээлэл, сургалчилгаа | | | | |
| 8. | Бусад үйл ажиллагаа | | | | |

Тайлан бичсэн: _____
Хянасан: _____

/Эмийн эмчилгээг зохицуулах хорооны нарийн бичиг/
/Эмийн эмчилгээг зохицуулах хорооны дараа/